



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 5 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ

/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилго

1.1.Энэ хуулийн зорилго нь хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр /цаашид “хууль тогтоомж” гэх/-ийг санаачлан боловсруулах, хууль тогтоомжийн төсөлд тавигдах шаардлагыг тодорхойлох, олон нийтийн оролцоог хангах, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, батлагдсан хууль тогтоомжийг нийтлэх, сурталчлах, түүний хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

[/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

2 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

2.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1.“хууль санаачлагч” гэж Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан этгээдийг;

2.1.2.“хууль санаачлах эрх” гэж Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйл болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хүрээ, хязгаарт нийцүүлэн энэ хуулийн 2.1.1-д заасан этгээдээс мэргэжлийн түвшинд боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг;

[/Энэ заал т ад 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

[/Энэ заал т ыг 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

2.1.3.“хуулийн төсөл” гэж хууль санаачлагчаас энэ хуульд заасан шаардлагыг ханган боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хуулийн төслийн эх бичвэрийг;

2.1.4.“Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл” гэж хууль санаачлагчаас энэ хуульд заасан шаардлагыг ханган боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх Улсын Их Хурлын тогтоолын төслийн эх бичвэрийг.

[/Энэ заал т ад 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

[/Энэ зүйлийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон./](#)

3.1.Энэ хууль нь хууль тогтоомжийг санаачлан боловсруулах, олон нийтийн оролцоог хангах, эрх зүйн дүгнэлт хийх, өргөн мэдүүлэх, батлагдсан хууль тогтоомжийг нийтлэх, олон нийтэд сурталчлах, түүний хэрэгжилтийг зохион байгуулах болон хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

[/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон./](#)

[/Энэ хэсэгт 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

4 дүгээр зүйл.Нийтлэг зарчим

4.1.Энэ хуулийг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан зарчмаас гадна дараах нийтлэг зарчмыг баримтална:

4.1.1.хүний эрх, эрх чөлөөг хангах хууль зүйн баталгааг бүрдүүлэх;

[/Энэ заал т ыг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

4.1.2.ил тод, нээлттэй байх;

[/Энэ заал т ын дугаар т 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

4.1.3.олон нийтийн оролцоог хангах;

[/Энэ заалтын дугаарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

4.1.4.ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

[/Энэ заалтын дугаарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

4.1.5.судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх.

[/Энэ заалтын дугаарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХУУЛЬ ТОГТООМЖ САНААЧЛАХ, ТӨЛӨВЛӨХ

5 дугаар зүйл.Хууль санаачлах

5.1.Хууль санаачлагч тодорхой хууль санаачлах бол Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйл болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хүрээ, хязгаарт нийцүүлэн, хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

[/Энэ хэсгийг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ заалтыг 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

5.2.Иргэн, хуулийн этгээд хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид уламжилна. Хууль санаачлагч уг саналыг үндэслэлтэй гэж үзвэл тухайн асуудлаар хууль санаачилж болно.

6 дугаар зүйл.Улсын Их Хурлын тогтоол санаачлах

6.1.Хууль санаачлагч Улсын Их Хурлын тогтоолыг санаачилж болно. Хуульд заасан тохиолдолд бусад байгууллага холбогдох саналаа хууль санаачлагчид уламжилна.

6.2.Улсын Их Хурлын дотоод зохион байгуулалт, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын үйл ажиллагааны тухай тогтоолыг холбогдох Байнгын хорооны түвшинд Улсын Их Хурлын гишүүд санаачилж болно.

6.3.Улсын Их Хурлын анхдугаар чуулганаар Улсын Их Хурлын дарга, дэд даргыг сонгох тухай Улсын Их Хурлын тогтоолд энэ хуулийн 6.1, 6.2 дахь хэсэг хамаарахгүй.

7 дугаар зүйл.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг төлөвлөх

7.1.Засгийн газар тухайн бүрэн эрхийнхээ хугацаанд санаачлах хууль тогтоомжийн талаар урьдчилан төлөвлөж, Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл /цаашид "Үндсэн чиглэл" гэх/-д тусгана.

7.2.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох байгууллагын саналыг авч, нэгтгэн судалсны үндсэн дээр Үндсэн чиглэлийн төслийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн боловсруулна.

7.3.Үндсэн чиглэлийн төсөлд санал өгөх байгууллага нь хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсны, эсхүл тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр уг асуудлаар анхдагч хууль болон шинэчилсэн найруулга гаргах, эсхүл хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагыг тодорхойлно.

[/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

7.4.Үндсэн чиглэлийн төслийг Засгийн газар баталж, Улсын Их Хуралд танилцуулна.

[/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

7.5.Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх хууль тогтоомжийн төслийн жагсаалт, дэс дарааллыг тогтоохдоо Үндсэн чиглэлд тусгагдсан хууль тогтоомжийн төслийг тэргүүн ээлжид хэлэлцэх зарчим баримтална.

7.6.Үндсэн чиглэлд тусгагдаагүй боловч хууль тогтоомжоор зохицуулах зайлшгүй шаардлагатай гэж үзвэл Засгийн газар холбогдох хууль тогтоомжийн төслийг санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

8 дугаар зүйл.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын үе шат

8.1.Хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

8.1.1.энэ хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, эсхүл энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт

үнэлгээ хийх;

[/Энэ заалт ад 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

8.1.2.энэ хуулийн 14, 15 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, батлах;

8.1.3.энэ хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн төслийг боловсруулах;

8.1.4.энэ хуулийн 17, 18 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог хийх;

8.1.5.эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлж, санал авах;

8.1.6.хууль тогтоомжийн төсөлд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагын саналыг авах;

8.1.7.хууль тогтоомжийн төсөлд эрх зүйн дүгнэлт хийх эрх бүхий этгээдээс санал, дүгнэлт авах;

[/Энэ заалтыг 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

8.1.8.хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;

8.1.9.энэ хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийг хангаж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

9 дүгээр зүйл.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг хариуцах

9.1.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг хууль санаачлагч хариуцан зохион байгуулна.

9.2.Засгийн газрын санаачлах хууль тогтоомжийн төслийг холбогдох төрийн захиргааны төв байгууллага Үндсэн чиглэлд заасны дагуу, өөхүл Засгийн газрын даалгавраар зөхиж хүрээ, салбарын асуудлаар хариуцан боловсруулна.

[/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

9.3.Хууль санаачлагч салбар хоорондын уялдааг хангах зорилгоор холбогдох байгууллагын удирдлагатай тохиролцож, тухайн асуудлыг хариуцсан албан тушаалтан болон судлаач, эрдэмтнийг хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажилд оролцуулж болно.

[/Энэ хэсэгт 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

9.4.Хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөл боловсруулахад шаардлагатай тооцоо, судалгаа, мэдээ, баримтыг холбогдох хуулийн этгээд, албан тушаалтнаас гаргуулан авах эрхтэй.

9.5.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах явцад холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллага, шинжээч, эрдэмтэн, иргэн, хуулийн этгээдээс санал авч, төсөл боловсруулахад харгалзан үзнэ.

10 дугаар зүйл.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах хэлбэр

10.1.Хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг дараах хэлбэрээр зохион байгуулна:

10.1.1.хууль тогтоомжийн төслийг өөрөө боловсруулах;

10.1.2.холбогдох байгууллагын албан тушаалтан, түүнчлэн судлаач, эрдэмтнээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулах;

[/Энэ заалт ад 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

10.1.3.иргэн, хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх.

11 дүгээр зүйл.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг санхүүжүүлэх

11.1.Хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөл боловсруулахтай холбогдон гарах зардлыг өөрийн төсвөөс санхүүжүүлнэ.

11.2.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг хууль тогтоох үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх зорилгогүйгээр ашгийн бус байгууллага санхүүжүүлж болно.

12 дугаар зүйл.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг арга зүйн удирдлагаар хангах

12.1.Засгийн газар дараах аргачлалыг баталж, мөрдүүлнэ:

12.1.1.хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал;

12.1.2.хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал;

12.1.3.хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал;

- 12.1.4.хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал;
- ~~12.1.5.хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийх аргачлал;~~
[/Энэ заалтыг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)
- 12.1.6.хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал.
- 12.2.Энэ хуулийн 12.1.2-12.1.6-д заасан аргачлал нь дараахь хууль тогтоомжийн төсөл боловсруулахад хамаарахгүй:
- ~~12.2.1.эээлийн хөлэлцээрээс бусад олон улсын гэрээс өөрхон батлах тухай;~~
[/Энэ заалтад 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)
[/Энэ заалтыг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)
[/Энэ заалтыг 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)
- 12.2.2.тухайн жилийн улсын төсөв, төсвийн тодотгол;
- 12.2.3.дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл;
- ~~12.2.4.улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр;~~
[/Энэ заалтыг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)
- 12.2.5.Засгийн газрын өрийн удирдлагын стратеги;
- 12.2.6.улсын төсвийн гүйцэтгэл батлах тухай;
- 12.2.7.Дайны байдлын тухай хуулийн 5.1, Дайн бүхий байдлын тухай хуулийн 5.1, Дайчилгааны тухай хуулийн 6.4-т заасан болон онц байдал, дайн бүхий болон дайны байдал, Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн, олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөлийн хугацаанд хууль санаачлагчаас тухайн нөхцөлийг арилгах, түүнийг даван туулахтай холбоотой санаачилсан хууль, Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл;
[/Энэ заалтад 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)
[/Энэ заалтад 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)
- 12.2.8.Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай;
[/Энэ заалтад 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)
- 12.2.9.Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох, чөлөөлөх;
[/Энэ заалтыг 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)
- 12.2.10.энэ хуулийн 6.2, 6.3-т заасан тогтоолын төсөл;
- 12.2.11.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.4, 4.1.5, 4.1.6, 4.1.8, 4.1.12, 4.1.13-т заасан баримт бичгийг батлах тухай;
[/Энэ заалтыг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)
- ~~12.2.12.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай;~~
[/Энэ заалтыг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)
- ~~12.2.13.улсын өдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай;~~
[/Энэ заалтыг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)
- ~~12.2.14.хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай;~~
[/Энэ заалтыг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)
- 12.2.15.төрөөс мөнгөний бодлогын талаар тухайн жилд баримтлах үндсэн чиглэл батлах тухай;
[/Энэ заалтад 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)
- 12.2.16.албан тушаалтныг томилох, чөлөөлөх тухай;
- ~~12.2.17.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21.1-д заасан хууль тогтоомжийн төсөл;~~
[/Энэ заалтад 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)
[/Энэ заалтыг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)
[/Энэ заалтыг 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)
- 12.2.18.Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3.4.1, 3.4.3-т заасан асуудлаар боловсруулсан хууль тогтоомжийн төсөл;
[/Энэ заалтыг 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)
- 12.2.19.дипломат харилцаа тогтоох тухай;
[/Энэ заалтыг 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

12.2.20.дипломат төлөөлөгчийн газрын түвшин, байршлыг тогтоох тухай;

[/Энэ заалтыг 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

12.2.21.төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч батлах тухай;

[/Энэ заалтыг 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

12.2.22.Монгол Улсын Их Хурлын тухай болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай;

[/Энэ заалт ад 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

[/Энэ заалтыг 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

[/Энэ заалтыг 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

12.2.23.онцгой албан татвар ногдуулах, хөнгөлөх, чөлөөлөх тухай Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл;

[/Энэ заалтыг 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

~~12.2.24.энэ хуулийн 24.2-т заасны дагуу хуулийн давхардал, хийдэл, өөрчлийг арилгах зорилгоор хэд хэдэн хуульд нэгэн зэрэг өөрчлөлт оруулахаар боловсруулсан хууль тогтоомжийн төсөл.~~

[/Энэ заалтыг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

[/Энэ заалтыг 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

[/Энэ хэсгийг 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

12.3.Энэ хуулийн 12.1.2-т заасан хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал дараах хууль тогтоомжийн төсөл боловсруулахад хамаарахгүй:

12.3.1.тухайн асуудлыг гагцхүү хуулиар зохицуулахаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан;

12.3.2.Монгол Улсын олон улсын гэрээгээр Монгол Улс тухайн асуудлаар дотоодын хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр боловсруулахаар тусгайлан үүрэг хүлээсэн;

12.3.3.энэ хуулийн 12.1.6-д заасан аргачлалын дагуу хийсэн үнэлгээгээр тухайн хуулийг шинэчлэн найруулах, эсхүл өөрчлөлт оруулах, хүчингүй болгох зөвлөмж гарсан.

[/Энэ хэсгийг 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

12.4.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасан хууль тогтоомжийн төсөл боловсруулахад энэ хуулийн 12.1.2, 12.1.3, 12.1.6-д заасан аргачлал хамаарахгүй.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

13 дугаар зүйл.Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах

13.1.Хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг энэ хуулийн 12.1.2-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.

13.2.Энэ хуулийн 12.1.2-т заасан аргачлалаар дараах асуудлыг судалж, зөвлөмж гаргана:

13.2.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуульд нийцэх эсэхийг судлах;

13.2.2.тухайн асуудлыг хууль тогтоомжоор зохицуулах шаардлагатай эсэхийг тодорхойлох;

13.2.3.тухайн асуудлыг зохицуулах эрх зүйн хэм хэмжээг тодорхойлох;

13.2.4.зохицуулах эрх зүйн хэм хэмжээний эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах;

13.2.5.хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг урьдчилан тооцсоны үндсэн дээр тухайн асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй хувилбарыг тодорхойлох;

13.2.6.шаардлагатай тохиолдолд тухайн асуудлаар гадаад улсын хууль тогтоомжийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгааг үндэсний эрх зүйн тогтолцооны онцлог, хөгжлийн чиг хандлагыг харгалзан оновчтой хувилбарыг үндэслэлийн хамт санал болгох зарчмыг баримтлан хийх.

[/Энэ заалтыг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

[/Энэ хэсгийг 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

13.3.Хууль санаачлагч хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааг анхдагч хуулийн төсөл болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд зарчмын шинжтэй зохицуулалт шинээр нэмж оруулж байгаа хуулийн төслийг боловсруулахад хийнэ.

[/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

14 дүгээр зүйл.Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төсөл боловсруулах

14.1.Хууль санаачлагч хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсны, эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр үзэл баримтлалын төсөл боловсруулна.

[/Энэ хэсэгт 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

14.2.Энэ хуулийн 14.1-д заасан үзэл баримтлалын төсөлд дараах асуудлыг тусгана:

14.2.1.хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага;

14.2.2.хууль тогтоомжийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ;

14.2.3.хууль тогтоомж батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал;

[/Энэ заалт ад 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

14.2.4.хууль тогтоомжийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал.

[/Энэ заалт ад 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

14.3.Энэ хуулийн 14.2.1-д заасан үндэслэл, шаардлагыг хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төсөлд тодорхой тайлбарлаж тусгана. Хууль тогтоомжийн төсөл нь хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаарт нийцэж байгаа эсэхийг үндэслэл, шаардлагад тодруулна.

[/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

14.4.Хууль санаачлагч тодорхой салбарын хоорондоо уялдаатай хэд хэдэн хуулийн төслийг нэгэн зэрэг хамтад нь хэлэлцүүлэхээр багцлан боловсруулж, өргөн мэдүүлж болно.

[/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

14.5.Энэ хуулийн 14.4-т заасны дагуу хэд хэдэн хуулийн төслийг багцлан боловсруулахдаа тухайн харилцааг зохицуулж байгаа ерөнхий хуулийг дагаж анхдагч хуулийн төсөл боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд төсөл тус бүрийн агуулгыг нэгтгэн нэг үзэл баримтлалаар тодорхойлж болно.

[/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

15 дугаар зүйл.Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалыг батлах

15.1.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн өөрийн санаачлах хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлж, батална.

15.2.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн санаачлах хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлж болно. Энэ тохиолдолд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн зөвлөмж гаргана.

15.3.Засгийн газрын санаачлах хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

[/Энэ хэсэгт 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

15.4.Хууль тогтоомжоор зохицуулах нийгмийн харилцаа нь Засгийн газрын хэд хэдэн гишүүний эрхлэх асуудлын хүрээнд хамаарч байвал хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

15.5.Төрийн захиргааны төв байгууллагын боловсруулсан санхүү, төсөв, татварын чиглэлээрх хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санхүү, төсвийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдтэй хамтран батална.

15.6.Олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг тухайн гэрээгээр зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гадаад хэргийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдтэй хамтран батална.

15.7.Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах нийгмийн харилцааг зохицуулсан хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг дангаар батална:

15.7.1.эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн эрх зүйн салбарын нийтлэг харилцаа;

[/Энэ заалтыг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

15.7.2.хуулиар тогтоосон эрхлэх асуудлын хүрээнд хамаарах асуудал.

15.8.Тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс ирүүлсэн хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг энэ хуулийн 15.3-15.6-д заасан Засгийн газрын гишүүн 30 хоногийн дотор хянан үзэж, дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

15.8.1.төслийг дэмжиж хамтран батлах;

15.8.2.төслийг дахин боловсруулах санал гаргаж, буцаах;

15.8.3.тухайн харилцааг хуулиар зохицуулах шаардлагагүй тухай дүгнэлт гаргах.

15.9.Энэ хуулийн 15.8.2, 15.8.3-т заасны дагуу хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг хянасан талаархи санал, дүгнэлтэд үндэслэлийг тодорхой заана.

15.10.Тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг хамтран батлуулахаар хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлэхдээ хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан, эсхүл тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн тайланг хамт ирүүлнэ.

[/Энэ зүйлийг 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

15.11.Энэ хуулийн 12.2.8-д заасан хуулийн төслийн үзэл баримтлалыг Монгол Улсын Ерөнхий сайд тодорхойлж, батлах бөгөөд хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу өргөн мэдүүлнэ.

[/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

15.12.Энэ хуулийн 22.1.3-т заасан хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулахдаа хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн нэрээр боловсруулж батлах бөгөөд хуулийн нэрийг өөрчлөх бол энэ талаар үзэл баримтлалын төсөлд тусгана.

[/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

15.13.Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалд баталсан он, сар, өдрийг тусгана.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

16 дугаар зүйл.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах

16.1.Хууль тогтоомжийн төслийг үзэл баримтлалд нь нийцүүлэн боловсруулна.

16.2.Хууль тогтоомжийн төслийг энэ хуулийн Дөрөвдүгээр бүлэг болон 12.1.1-д заасан аргачлалын дагуу боловсруулна.

16.3.Хууль тогтоомжийн төсөл боловсруулахдаа бусад хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт, тэдгээрийг дагаж гарах шийдвэрийн төслийг хамт боловсруулж, холбогдох тооцоо, судалгаа хийсэн байна.

16.4.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хууль тогтоомжийн төсөл боловсруулах талаар төрийн захиргааны төв байгууллага болон бусад байгууллагад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч болно.

17 дугаар зүйл.Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх

17.1.Хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээг хөндлөнгийн судлаач, хуулийн этгээдээр энэ хуулийн 12.1.3-т заасан аргачлалын дагуу гүйцэтгүүлнэ.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

17.2.Энэ хуулийн 12.1.3-т заасан аргачлалын дагуу хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг шалгуур үзүүлэлтийг сонгох, хуулийн төслөөс үр нөлөөг тооцох хэсгийг сонгох, үр нөлөөг тооцох, үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх үе шаттайгаар дараах байдлаар үнэлж, зөвлөмж гаргана:

[/Энэ хэсэгт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

17.2.1.хууль тогтоомжийн төсөл, эсхүл түүний зарим зүйл, заалтын зохицуулалтын практикт хэрэгжих боломж, харилцан уялдаа зэргийг тооцож шинжилгээ хийх;

17.2.2.хууль тогтоомжийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах;

17.2.3.хууль тогтоомжийн төслийг батлан хэрэгжүүлснээр үүсэж болзошгүй, урьдчилан тооцоогүй үр дагаврыг тодорхойлох.

17.2.4.хууль тогтоомжийн төслийн хүний эрхэд нөлөөлөх байдлыг үнэлэх.

[/Энэ заалтыг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

17.3.Тухайн хуулийн төслөөр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах тохиолдолд дараах шаардлагыг хангасан эсэхийг энэ хуулийн 17.2.4-т заасан үнэлгээнд нэмж тусгана:

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

17.3.1.үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн хэв журмыг хамгаалах зайлшгүй шаардлага бүхий байх;

[/Энэ заал тын 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

17.3.2.ялгаварлан гадуурхаагүй байх;

[/Энэ заал тыг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

17.3.3.хязгаарлалт нь зорилгодоо хүрэхэд тохирсон, боломжит хамгийн бага түвшинд байх.

[/Энэ заал тыг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

17.4.Хууль тогтоомжийн төслийг батлан хэрэгжүүлснээр гарах үр нөлөөг тооцсоны үндсэн дээр шаардлагатай бол тухайн хууль тогтоомжийн төсөл, эсхүл түүний зарим зүйл, заалтыг дахин боловсруулна.

[/Энэ хэсгийн дугаарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

18 дугаар зүйл.Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцох

18.1.Хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийг баталснаар үүсэх зардлын тооцоог гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу дараах байдлаар үнэлж, тодорхойлно:

18.1.1.хууль тогтоомжийн төслийн улсын төсөвт үзүүлэх нөлөөллийг тооцох;

18.1.2.хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг тооцох."

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

18.2.Энэ хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах болон энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалыг баримталж болно.

[/Энэ хэсэг т 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

18.3.Улсын Их Хурлын гишүүний санаачилсан хууль тогтоомжийн төсөлд Улсын Их Хурлын Тамгын газар, эсхүл хууль зүйн, төсвийн судалгааны чиглэлийн хүн, хуулийн этгээд энэ хуулийн 18.1-д заасан зардлын тооцоог хийнэ.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

19 дүгээр зүйл.Хууль тогтоомжийн төсөлд эрх зүйн дүгнэлт хийх

19.1.Засгийн газрын санаачилсан хууль тогтоомжийн төсөл энэ хуульд заасан шаардлагыг хангасан эсэхэд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрх зүйн дүгнэлт хийнэ.

19.2.Хууль санаачлагчийн боловсруулсан хууль тогтоомжийн төсөл энэ хуульд заасан шаардлагыг хангасан эсэхэд Улсын Их Хурлын Тамгын газар эрх зүйн дүгнэлт хийнэ.

[/Энэ зүйлийг 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

19¹ дүгээр зүйл.Яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн төсөлд хууль зүйн дүгнэлт хийх

[/Энэ зүйлийг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

19¹.1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан хууль тогтоомжийн төсөл энэ хуульд заасан шаардлагыг хангасан эсэхэд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хууль зүйн дүгнэлт гаргаж ирүүлсэн байна.

[/Энэ хэсгийг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

20 дугаар зүйл.Засгийн газрын санаачилсан хууль тогтоомжийн төсөлд санал авах, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх

20.1.Төрийн захиргааны төв байгууллагын боловсруулсан хууль тогтоомжийн төсөлд холбогдох төрийн захиргааны төв байгууллага 30 хоногийн дотор саналаа өгнө.

20.2.Энэ хуулийн 20.1-д заасан хугацаанд саналаа ирүүлээгүй бол тусгайлан өгөх саналгүй гэж үзнэ.

20.3.Төрийн захиргааны төв байгууллага боловсруулсан хууль тогтоомжийн төсөлдөө бусад төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох төрийн байгууллагын саналыг бичгээр авч, үндэслэлтэй гэж үзвэл тухайн төсөлд тусгана.

[/Энэ хэсэг т 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан./](#)

20.4.Төрийн захиргааны төв байгууллага боловсруулсан хууль тогтоомжийн төслөө түүний үзэл баримтлал, танилцуулга, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан, эсхүл тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн

хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийсэн тайлангийн хамт хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулахаар хүргүүлнэ. Хууль тогтоомжийн төсөл төсвийн зардал нэмэгдүүлэх, орлого бууруулах үр дагаврыг бий болгохоор бол санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулахаар хүргүүлнэ.

[/Энэ хэсэгт 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

20.5.Хууль тогтоомжийн төсөл энэ хуульд заасан шаардлагыг хангаагүй бол хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн уг төслийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагад үндэслэл бүхий тайлбарын хамт буцаана.

[/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

20.6.Энэ хуулийн 20.5-д заасны дагуу хууль тогтоомжийн төслийг буцаасан тохиолдолд төрийн захиргааны төв байгууллага тухайн төслийг дахин боловсруулж, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулахаар хүргүүлнэ.

20.7.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Засгийн газрын санаачлах хууль тогтоомжийн төсөл төсвийн зардал нэмэгдүүлэх, орлого бууруулах эсэхийг хянаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгоно.

[/Энэ хэсэгт 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

20.8.Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Засгийн газрын санаачлах хууль тогтоомжийн төсөл энэ хуульд заасан шаардлагад нийцсэн эсэхийг эцэслэн хянаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгоно.

[/Энэ хэсэгт 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

20.9.Гадаад хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгоно.

20.10.Энэ хуулийн 20.7-20.9-д заасан зөвшөөрлийг бичгээр, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр үйлдэнэ.

[/Энэ хэсэгт 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

20.11.Энэ хуулийн 20.10-т заасан зөвшөөрлийг авсны үндсэн дээр төрийн захиргааны төв байгууллага боловсруулсан хууль тогтоомжийн төслөө Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

20.12.Хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан дэгийг баримтална.

[/Энэ хэсгийг 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

21 дүгээр зүйл.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүний санаачилсан хууль тогтоомжийн төсөлд Засгийн газрын санал, дүгнэлтийг авах, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх

21.1.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн санаачилсан хууль тогтоомжийн төслөө түүний үзэл баримтлал, танилцуулга, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан, эсхүл тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийсэн тайлангийн хамт санал, дүгнэлт авахаар Засгийн газарт хүргүүлнэ.

[/Энэ хэсэгт 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

21.2.Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хууль тогтоомжийн төслийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор Засгийн газрын санал, дүгнэлтийн төслийг бэлтгүүлэхээр хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

21.3.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүний санаачилсан хууль тогтоомжийн төслийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор Засгийн газрын бусад гишүүн, холбогдох байгууллагад хүргүүлнэ.

21.4.Энэ хуулийн 21.3-т заасан байгууллага, албан тушаалтан нь Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүний санаачилсан хууль тогтоомжийн төсөлд өгөх саналыг тухайн хууль тогтоомжийн төслийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор бэлтгэж, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

21.5.Төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 21.4-т заасан хугацаанд саналаа ирүүлээгүй бол тусгайлан өгөх саналгүй гэж үзнэ.

21.6.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын бусад гишүүнээс ирүүлсэн саналыг Засгийн газрын санал, дүгнэлтийн төсөлд тусгахдаа дараах зарчмыг баримтална:

21.6.1.зарчмын шинжтэй саналуудыг нэг бүрчлэн томьёолох;

21.6.2.хэл зүй, найруулга, томъёоллын шинжтэй саналуудыг багцлах.

21.7.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 21.4-т заасан хугацаа өнгөрсөн өдрөөс хойш ажлын долоон өдрийн дотор Засгийн газрын санал, дүгнэлтийн төслийг бэлтгэж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

21.8.Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Засгийн газрын санал, дүгнэлтийн төслийг энэ хуулийн 21.7-д заасны дагуу хүлээн авсан өдрөөс хойш ажлын долоон өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

21.9.Энэ хуулийн 21.7-д заасан Засгийн газрын санал, дүгнэлтийн төсөлд дараах асуудлыг тусгана:

21.9.1.тухайн хууль тогтоомжийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль болон хууль зүйн бодлогод нийцэж байгаа эсэх, түүний үзэл баримтлалыг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг дэмжиж байгаа эсэх үндэслэл, тайлбар ;

[/Энэ заал т ад 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

[/Энэ заал т ад 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмэл т оруулсан../](#)

[/Энэ заал т ад 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан/](#)

21.9.2.тухайн хууль тогтоомжийн төсөл бусад хууль тогтоомжтой уялдсан эсэх;

[/Энэ заал т ыг 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд т ооцсон/](#)

21.9.3.тухайн хууль тогтоомжийн төсөл энэ хуульд заасан шаардлагыг хангасан эсэх.

21.10.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүний санаачилсан хууль тогтоомжийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлага, Төсвийн тухай хуульд заасан төсвийн бусад шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг хангаж байгаа эсэх талаарх Засгийн газрын дүгнэлтийг бэлтгэж, энэ хуулийн 21.4-т заасан хугацаанд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.

[/Энэ хэсэг т 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

21.11.Засгийн газар санал, дүгнэлтээ ажлын 30 өдрийн дотор хууль санаачлагчид хүргүүлнэ. Шаардлагатай тохиолдолд хууль санаачлагчтай тохиролцон түүний бичгээр, эсхүл энэ хуулийн 20.10-т заасан цахим хэлбэрээр өгсөн зөвшөөрлийг үндэслэн уг хугацааг сунгаж болно.

[/Энэ хэсэг т 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

[/Энэ хэсэг т 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар нэмэл т оруулсан./](#)

[/Энэ хэсэг т 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар нэмэл т оруулсан./](#)

21.12.Засгийн газар энэ хуулийн 21.11-д заасан хугацаанд санал, дүгнэлтээ ирүүлээгүй бол тусгайлан өгөх саналгүй гэж үзнэ.

[/Энэ хэсэг т 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

21.13.Засгийн газар энэ хуулийн 21.1-д заасан хууль тогтоомжийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль болон хууль зүйн бодлогод нийцээгүй, тухайн хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалыг бүхэлд нь дэмжих боломжгүй, энэ хуульд заасан шаардлагыг хангаагүй гэсэн дүгнэлт гаргасан тохиолдолд уг дүгнэлтийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд заавал танилцуулна.

[/Энэ хэсэг т 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

[/Энэ хэсэг т 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмэл т оруулсан./](#)

21.14.Улсын Их Хурлаас шийдвэр гаргахаар хууль тогтоомжид заасан болон Улсын Их Хурлын үйл ажиллагаа, хуралдааны дотоод зохион байгуулалттай холбоотой хууль тогтоомжийн төсөлд Засгийн газраас санал авахгүй байж болно.

[/Энэ хэсгийг 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ **ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТӨРӨЛ, БҮТЭЦ, ХЭЛБЭР, ЭХ БИЧВЭРТ ТАВИХ** **ШААРДЛАГА**

22 дугаар зүйл.Хуулийн төслийн төрөл

22.1.Хуулийн төсөл дараах төрөлтэй байна:

22.1.1.анхдагч хуулийн төсөл;

22.1.2.хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл;

22.1.3.хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

22.1.4.багц хуулийн төсөл;

[/Энэ заалтыг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

22.1.5.хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл.

[/Энэ заалтыг 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

23 дугаар зүйл.Анхдагч хуулийн төсөл

23.1.Хууль санаачлагч нийгмийн харилцааны төлөв байдал, тулгамдсан асуудлыг судалсны үндсэн дээр шинээр үүссэн харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай, эсхүл тухайн нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай гэж үзвэл анхдагч хуулийн төсөл боловсруулна.

24 дүгээр зүйл.Хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл

24.1.Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр тухайн хуульд нэмэлт оруулах, хуулийн зарим зүйл, заалтыг өөрчлөн найруулах, эсхүл тодорхой зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох асуудлаар хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулна.

[/Энэ хэсэгт 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

24.2.Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хэд хэдэн хуульд нэгэн зэрэг өөрчлөлт оруулах хуулийн төслийг Засгийн газар санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно. Энэ тохиолдолд өөрчлөлт оруулж байгаа хууль тус бүрд үзэл баримтлалыг тодорхойлох шаардлагагүй.

24.3.Хуулийн өөрчлөлтийг хуулийн анхдагч эх бичвэрт оруулна.

24.4.Тухайн хуульд нэмэлт оруулах бол "нэмэлт оруулах тухай", өөрчлөлт оруулах бол "өөрчлөлт оруулах тухай", нэмэлт, өөрчлөлт аль алийг нь оруулах бол "нэмэлт, өөрчлөлт оруулах тухай", хуулийн зүйл, заалтыг хүчингүй болгох бол "хүчингүй болсонд тооцох тухай" гэж хуулийн төслийг ялгавартай нэрлэнэ.

[/Энэ хэсэгт 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

24.5.Хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл нь дараах төрөлд хуваагдана:

24.5.1.хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;

24.5.2.хуульд нэмэлт оруулах тухай;

24.5.3.хуульд өөрчлөлт оруулах тухай;

24.5.4.хуулийн зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай.

[/Энэ заалтад 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

24.6.Хуульд оруулах өөрчлөлтийг зөвхөн нэг хуульд хамааруулж хийх бөгөөд өөрчлөлт орж байгаа хуулийн нэр, зүйл, хэсэг, заалтын дугаарыг тодорхой бичнэ.

24.7.Хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөлд зүйлийн гарчиг тавилгүйгээр зүйлийн агуулгыг дугаарын хойноос шууд бичнэ.

24.8.Хуулийн нэг зүйлд хэд хэдэн өөрчлөлт оруулж байгаа бол өөрчлөлт тус бүрийг бие даасан заалт болгон тэмдэглэнэ.

24.9.Өөрчлөлт оруулж байгаа зүйл, хэсэг, заалтын зарим нэр томьёо, үг хэллэгийг өөрчилсөн буюу хассанаар түүний утга агуулга нэг мөр ойлгогдохооргүй байвал түүнийг өөрчлөн найруулна.

24.10.Хүчингүй болсонд тооцож байгаа хуулийн төслийн заалтад тухайн хуулийн хүчингүй болсонд тооцох бүх зүйл, хэсэг, заалтыг тусгана.

24.11.Хэрэв хуулийн төсөлтэй хөлбөгдөн хэд хэдэн хуульд нэр томьёоны өөрчлөлт оруулах бол хууль бүрд оруулах өөрчлөлтийг тусгаасан нэг хуулийн төсөл боловсруулж болно.

[/Энэ хэсгийг 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

25 дугаар зүйл.Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

25.1.Дараах тохиолдолд хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулна:

25.1.1.өмнө нь тухайн хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нь нэмэлт, өөрчлөлт орсон бол;

25.1.2.хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны улмаас хуулийн бүтэц, уялдаа алдагдахад хүрэх, эсхүл тухайн хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орох бол;

25.1.3.хуулийн үзэл баримтлалыг бүхэлд нь өөрчлөхөд хүргэсэн нэмэлт, өөрчлөлт орох бол;

25.1.4. тухайн хуулиар зохицуулж байгаа нийгмийн харилцааны төлөв байдал, агуулгад ихээхэн өөрчлөлт гарч, түүнтэй уялдуулан хуулийг шинэчлэн батлах шаардлагатай болсон.

25.2. Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахдаа анхдагч хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хамтад нь боловсруулна.

26 дугаар зүйл. Багц хуулийн төсөл

/Энэ зүйлийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./

26.1. Хууль — санаачлагч тодорхой салбарын хоорондоо уялдаатай хэд хэдэн хуулийн төслийг нэгэн зэрэг хамтад нь хэлэлцүүлэхээр багц хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлж болно. Энэ тохиолдолд хууль тус бүрийн үзэл баримтлалыг тодорхойлно.

/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./

/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

26¹ дүгээр зүйл. Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл

26¹.1. Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийг хүчингүй болгосноор өмнө нь хүчингүй болсон хуулийн үйлчлэл сэргэхгүй.

/Энэ зүйлийг 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар нэмсэн/

26¹.2. Тухайн хуульд хуулийн үйлчлэх хугацааг заасан тохиолдолд тус хугацаа дуусмагц хууль хүчингүй болно.

/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн./

26¹.3. Тухайн хуульд өөрөөр заагаагүй бол хуулийг буцаан хэрэглэхгүй.

/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн./

27 дугаар зүйл. Хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт

27.1. Хуулийг дагаж мөрдөх журмаар дараах асуудлыг зохицуулна:

27.1.1. хууль бүхэлдээ, эсхүл хуулийн тодорхой анги, хэсэг, бүлэг, зүйл, заалт хүчин төгөлдөр үйлчилж эхлэх нөхцөл;

27.1.2. хууль хэрэгжүүлэхтэй холбоотой зохион байгуулалт, шилжилтийн үе шатны бэлтгэлийг хангах, шинэ бүтэц, ажлыг гүйцэтгэх нөхцөл;

27.1.3. өмнө үйлчилж байсан хууль, эрх зүйн зохицуулалтын дагуу үүссэн харилцаа, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүргийг шинэ хуулийн дагуу хэрхэн хамгаалах, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, өөрчлөх, хүчингүй болсонд тооцох болон сөрөг үр дагаврыг арилгах нөхцөл, арга зам, хариуцлагыг зохицуулах хэлбэр;

27.1.4. хууль үйлчилж эхэлсэнтэй холбоотой аливаа зардал, нөхөх олговор, хохирлыг нөхөн төлөх нөхцөл;

27.1.5. өмнөх хууль, эрх зүйн зохицуулалт, тэдгээрийн зарим хэсэг хүчин төгөлдөр үйлчлэх тодорхой нөхцөл, тохиолдол;

27.1.6. хууль буцаж үйлчлэх онцгой тохиолдол.

27¹ дүгээр зүйл. Хуулийн төсөлд захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалт тусгахад тавих шаардлага

/Энэ зүйлийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./

27¹.1. Хуулийн төсөлд захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалт тусгахад дараах шаардлагыг хангасан байна:

/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./

27¹.1.1. хуулийн тодорхой зүйл, хэсэг, заалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх;

/Энэ заалтыг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./

27¹.1.2. тухайн хуулийн зорилго, зорилт, үйлчлэх хүрээнд нийцсэн байх;

/Энэ заалтыг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./

27¹.1.3. захиргааны хэм хэмжээний акт батлахад баримтлах тухайлсан зарчмыг тодорхойлсон байх;

/Энэ заалтыг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./

27¹.1.4. зорилго, зохицуулах харилцааны хүрээг тодорхой тусгасан байх;

/Энэ заалтыг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./

27¹.1.5. захиргааны хэм хэмжээний акт батлах байгууллага, албан тушаалтныг тодорхойлсон, тухайн этгээдийн хуульд

заасан чиг үүрэгт хамааралтай байх;

[/Энэ заал т-ыг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

27¹.1.6.хуулиар тогтоосон иргэн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулаагүй байх.

[/Энэ заал т-ыг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

27¹.2.Дараах асуудлаар захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгохгүй:

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

27¹.2.1.Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хуулиар тогтоосноос гадуур хязгаарлах, хариуцлага оногдуулах;

[/Энэ заал т-ыг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

27¹.2.2.Монгол Улсын Үндсэн хуульд гагцхүү хуулиар тогтоохоор заасан харилцаа;

[/Энэ заал т-ыг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

27¹.2.3.эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацаа;

[/Энэ заал т-ыг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

27¹.2.4.гомдол, маргааныг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны зарчим, хугацаа, оролцогчдын эрх, үүрэг.

[/Энэ заал т-ыг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

Тайлбар: гомдол, маргааныг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны зарчим, хугацаа, оролцогчдын эрх, үүргийг зөвхөн хуулиар тогтоох бөгөөд бусад асуудлыг захиргааны хэм хэмжээний актаар тогтоож болно.

[/Энэ тайлбарыг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

27¹.3.Захиргааны хэм хэмжээний акт гаргах хугацааг энэ хуулийн 27.1-д заасан хуулийг дагаж мөрдөх журамд тусгана.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

28 дугаар зүйл.Хуулийн төслийн бүтэц, хэлбэр

28.1.Хуулийн төсөл дараах бүтэцтэй байна:

28.1.1.хуулийн төслийн гарчиг, бүтцийн товьёг ;

[/Энэ заал т-ад 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

28.1.2.хуулийн төслийн бүтцийн үндсэн нэгж болох зүйл;

28.1.3.зүйлийн доторх хэсэг;

28.1.4.хэсгийн доторх заалт;

28.1.5.заалтын доторх дэд заалт;

28.1.6.шаардлагатай бол бүлэг, дэд бүлэг, хэсэг, дэд хэсэг, анги.

28.2.Хуулийн төслийн бүтэц дараах шаардлагыг хангасан байна:

28.2.1.зүйл нь хоорондоо уялдаа холбоо, дэс дараалал бүхий, агуулгыг товч илэрхийлсэн гарчиг, нэгдсэн дугаартай байх;

28.2.2.бие даасан санаа бүрийг зүйлд тусгах;

28.2.3.өгүүлбэрүүд нь нэг санааг илэрхийлж байвал нэг хэсэгт тусгах ба бие даасан санаа нь хэд хэдэн өгүүлбэрээр илэрхийлэгдэж байвал зүйлийг хэсэгт хуваах;

[/Энэ заал т-ад 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

28.2.4.заалт нь аль болох цөөн өгүүлбэрээс бүрдсэн байх;

[/Энэ заал т-ад 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

28.2.5.зүйлүүдийг сэдвээр нь бүлэглэж, бүлгийг хэсэг, ангид нэгтгэх.

[/Энэ заал т-ад 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

28.3.Хуулийн төслийн бүтцийг дараах дарааллаар байрлуулна:

[/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

28.3.1.хуулийн төслийн гарчиг, бүтцийн товьёг;

[/Энэ заал т ад 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

28.3.2.нийтлэг хэм хэмжээ тогтоож байгаа зүйлийг нэгтгэсэн "ерөнхий анги", эсхүл "нийтлэг үндэслэл" гэсэн бүлэг, хэсэг;

28.3.3.цагаан толгойн үсгийн дарааллаар байрлуулсан нэр томъёоны тайлбар;

[/Энэ заал т ад 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

28.3.4.тусгайлсан хэм хэмжээ тогтоож байгаа зүйлийг нэгтгэсэн тусгай "анги", эсхүл агуулгаар нь бүлэг, хэсэг болгосон эрх зүйн хэм хэмжээ;

28.3.5.иргэн, хуулийн этгээдээс үйл ажиллагаа явуулах журам, тэдгээрийн эрх, үүрэг;

28.3.6.асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон бусад төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа явуулах журам, бүрэн эрх;

[/Энэ заал т ыг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

28.3.7.онцгойлон үзэх нөхцөл байдал;

[/Энэ заал т ын дугаар т 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

28.3.8.хариуцлага тогтоож байгаа хэм хэмжээ;

[/Энэ заал т ын дугаар т 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

28.3.9.хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт;

[/Энэ заал т ын дугаар т 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

28.3.10.шаардлагатай бол хууль хүчин төгөлдөр болох тухай хэм хэмжээ;

[/Энэ заал т ын дугаар т 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

28.3.11.бусад зүйл.

[/Энэ заал т ын дугаар т 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

28.4.Хуулийн төслийн гарчиг дараах зүйлээс бүрдэнэ:

28.4.1."Монгол Улсын хууль" гэсэн толгой;

28.4.2.хуулийг баталсан он, сар, өдөр /араб тоогоор бичнэ/;

28.4.3.хуулийг баталсан газар /хот/-ын нэр;

28.4.4.агуулгыг товч, тодорхой илэрхийлсэн хуулийн нэр.

28.5.Энэ хуулийн 28.4.4-т заасан хуулийн нэрийг дан том үсгээр бичих бөгөөд дараах төрөлтэй байна:

28.5.1.тухайлсан нь: "... тухай" гэсэн үгээр төгсгөнө. /АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ, МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ г.м/

28.5.2.оноосон нь: "...-ийн хууль" гэдэг үгээр төгсгөнө. /ИРГЭНИЙ ХУУЛЬ, АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ г.м/

28.6.Хуулийн төслийн бүтцийн хэсгийг дараах байдлаар дугаарлана:

28.6.1.анги, хэсгийг ром тоогоор, эсхүл бичгээр;

28.6.2.бүлгийг бичгээр;

28.6.3.зүйлийг араб тоогоор, ард нь "дүгээр", эсхүл "дугаар" зүйл гэж бичгээр /1 дүгээр зүйл. г.м/;

28.6.4.зүйлийн доторх хэсгийг баруун талдаа цэгтэй араб тоогоор /1.1. г.м./;

28.6.5.зүйлийн доторх хэсгийн доторх заалтыг баруун талдаа цэгтэй араб тоогоор /1.1.1. г.м/;

28.6.6.заалтын доторх дэд заалтыг үсгээр /1.1.1.а. г.м/.

28.7.Зохицуулах харилцааны онцлогоос хамаарч шаардлагатай тохиолдолд хуулийн төслийн бүтцийн хэсгийг дараах байдлаар дугаарлаж болно:

28.7.1.зүйлийг дугаарлахдаа зүйлийн дугаарын өмнө нь баруун талдаа цэгтэй тухайн бүлгийн дугаарыг араб тоогоор бичиж, ард нь "дүгээр", эсхүл "дугаар" гэж бичгээр /1.1 дүгээр зүйл. г.м/;

28.7.2.хэсгийг баруун талдаа цэгтэй араб тоогоор /1. г.м./;

28.7.3.хэсгийн доторх заалтыг баруун талдаа цэгтэй араб тоогоор /1.1. г.м/;

28.7.4.заалтын доторх дэд заалтыг үсгээр /1.1.а. г.м/.

28.8.Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн заалтыг дараах дарааллаар байрлуулна:

- 28.8.1.хуульд нэмэлт оруулах;
- 28.8.2.хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг өөрчлөн найруулах;
- 28.8.3.хуулийн зарим нэр томьёо, үг, өгүүлбэрийг өөрчлөх;
- 28.8.4.хуулийн зарим үг, өгүүлбэрийг хасах;
- 28.8.5.зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох;
- 28.8.6.шаардлагатай бол хуулийг дагаж мөрдөх хугацаа.

28.9.Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл доторх заалтыг баруун талдаа хаалт бүхий араб тоогоор дугаарлана /1/ г.м/.

28.10.Хуульд шинээр нэмэгдэх зүйл нь анхдагч эх бичвэрийн тухайн зүйл заалтаас салшгүй утга агуулгатай бол дугаарыг тэмдэглэхдээ баруун дээд өнцөгт нь жижиг араб тоогоор дугаарлана /52¹ дүгээр зүйл г.м/.

29 дүгээр зүйл.Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага

29.1.Хуулийн төслийн агуулга дараах нийтлэг шаардлага хангасан байна:

- 29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байх;
[/Энэ заал т ад 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)
- 29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;
- 29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;
- 29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;
- 29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;
- 29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;
- 29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;
- 29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох зарчим, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг тусгасан байх.
[/Энэ заал т ад 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмэл т, өөрчлөл т оруулсан./](#)
- 29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;
[/Энэ заал т ыг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)
- 29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;
[/Энэ заал т ыг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)
- 29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.
[/Энэ заал т ыг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

29.2.Хуулийн төсөлд шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох, зарим үг, өгүүлбэр, тоо, тэмдэгт хасах талаар тусгана.

[/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

29.3.Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулна.

[/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

29.4.Энэ хуулийн 14.5-д зааснаас бусад хуулийн төслийг дагалдуулан анхдагч болон шинэчилсэн найруулгын төслийг өргөн мэдүүлэхийг хориглоно.

[/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

29.5.Энэ хуулийн 12.2.2-т заасан хуулийн төслийг дагалдуулан зөвхөн тухайн жилийн төсөвт нөлөөлөл үзүүлэх хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлэх бөгөөд энэ тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслийн төсвийн орлого, зарлага, төсвийн тэнцэлд үзүүлэх нөлөөлөл, холбогдох тооцооллыг хуулийн төслийн танилцуулгад тодорхой тусгана.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

30 дугаар зүйл.Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага

30.1.Хуулийн төслийн хэл зүй, найруулга дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;

30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;

30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;

30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;

30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.

30.2.Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн дэргэд хууль зүйн нэр томъёог шинжлэх ухааны үндэслэлтэй оноон тодорхойлох, жигдлэн хэвшүүлэх, нэр томъёотой холбогдсон асуудлаар зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий Хууль зүйн хэлний зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/ ажиллана. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

[/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

30.3.Зөвлөл нь энэ хуулийн 30.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэхдээ Монгол хэлний тухай хуульд заасан Хэлний бодлогын үндэсний зөвлөлтэй хамтран ажиллаж, тодруулга авч болно.

[/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

30.4.Хуулийн төсөлд дараах тохиолдолд нэр томъёоны тайлбар хийнэ:

30.4.1.нэр томъёо нь олон утгатай бол;

30.4.2.нэр томъёо нь өргөн утгатай бөгөөд түүнийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай бол;

30.4.3.шинээр бий болсон ойлголт буюу нэр томъёо нь нийтэд ойлгомжгүй бол.

30.5.Хуулийн төсөлд дараах тохиолдолд гадаад хэлний нэр томъёо хэрэглэж болно:

30.5.1.үг нэр томъёог оноосон нэр монгол хэлэнд байхгүй бол;

30.5.2.үг нэр томъёог олон улсын хэмжээнд нийтлэг хэрэглэж хэвшсэн бол;

30.5.3.үг нэр томъёог Монгол Улсын олон улсын гэрээнд хэрэглэж байгаа бол.

30.6.Нэр томъёо нь нэг утга агуулгаар нийт хуулийн хэмжээнд хэрэглэгдэх бол түүний тодорхойлолтыг уг хуулийн "Нийтлэг үндэслэл" гэсэн бүлэгт оруулан заана. Хуулийн төсөлд тодорхойлолт өгсөн хэд хэдэн нэр томъёо байгаа бол тэдгээрийг "Хуулийн нэр томъёоны тодорхойлолт" гэсэн гарчигтай зүйлд нэгтгэнэ.

30.7.Нэр томъёо нь тодорхой утга агуулгаар зөвхөн нэг бүлэг, зүйл, хэсэг, заалтын хүрээнд хэрэглэгдэх бол түүний тодорхойлолт, тайлбарыг холбогдох бүлэг, зүйл, хэсэг, заалтын дотор байрлуулж болно.

[/Энэ хэсгийг 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

30.8.Хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуульд заасан агуулга ижил нэр томъёог дагаж өөрчлөх шаардлагатай тохиолдолд ижил утгаар ойлгож хэрэгжүүлэх, хэрэглэх тайлбарыг хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалтад тусгаж болно.

[/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

31 дүгээр зүйл.Хуулийн төсөлд товчлол хэрэглэх

31.1.Хуулийн төсөлд олон дахин давтагдаж байгаа нэг ойлголт, нэр томъёог хэд хэдэн үгээр илэрхийлэх тохиолдолд тэдгээрийг цөөн үгээр хэрэглэх зорилгоор товчлол хэрэглэнэ.

31.2.Дараах тохиолдолд товчлол хэрэглэхгүй:

31.2.1.хуулийн нэр, бүлэг, зүйлийн гарчигт;

31.2.2.тухайн үг олон удаа давтагдаагүй бол;

31.2.3.бусад хуульд хэрэглэсэн нэр томъёотой андуурахуйц байгаа бол.

32 дугаар зүйл.Хуулийн төсөлд эшлэл хэрэглэх

32.1.Хуулийн давхардал, зөрчил гарахаас сэргийлэх, ойлгож хэрэглэхэд хялбар болгох зорилгоор өөр хуульд байгаа, эсхүл тухайн хуульд нэгэнт туссан асуудлыг дахин дурдах бол эшлэл хэрэглэнэ.

32.2.Хуульд бусад хуулиас эшлэл хийхдээ тухайн заалтыг эх бичвэрээр нь хуулбарлахыг хориглоно.

33 дугаар зүйл.Хуулийн төслийн танилцуулга

33.1.Хууль санаачлагч хуулийн төслийн талаар товч болон дэлгэрэнгүй танилцуулга бэлтгэнэ.

[/Энэ хэсэг т. 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

33.2.Хуулийн төслийн товч танилцуулгад дараах мэдээллийг тусгана:

[/Энэ хэсэг т 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

33.2.1.хуулийн төслийн ерөнхий агуулга, зохицуулах харилцаа, хуулийн төсөлд тусгасан зарчмын шинжтэй зохицуулалтын талаар;

[/Энэ заалтыг 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

33.2.2.тухайн харилцааг урьд нь хууль, эрх зүйн бусад актаар зохицуулж ирсэн байдал;

33.2.3.хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан хууль санаачлагчаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;

33.2.4.хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн дүн;

33.2.5.гадаад орны туршлага, бусад судалгаа, шинжилгээний тайлангийн дүгнэлт.

33.3.Хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгад хуулийн төсөл болон дагаж гарах хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрд дараах мэдээллийг агуулсан тайлбарыг тусгана:

[/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

33.3.1.нэмэлт, өөрчлөлт оруулах, өөрчлөн найруулах, үг, өгүүлбэрийг хасах, хүчингүй болсонд тооцох болсон үндэслэл, шаардлага;

[/Энэ заалтыг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

33.3.2.зохицуулахаар тусгасан харилцааны агуулга, зохицуулалтыг хэрхэн ойлгох тухай;

[/Энэ заалтыг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

33.3.3.хуулийн төсөлтэй холбогдуулан гадаад улсын хууль тогтоомжийн зохицуулалтад харьцуулалт хийж, тусгасан тохиолдолд тэдгээрийн талаарх тайлбар, дүгнэлт;

[/Энэ заалтыг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

33.3.4.нэр томьёо, ухагдахууны үүсэл, нэр томьёог нийцүүлсэн талаарх тайлбар.

[/Энэ заалтыг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

[/Энэ заалтын дугаарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ заалтад 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

33.4.Хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгад энэ хуулийн 33.3-т заасан тайлбарыг шинэчилсэн найруулга бол бүлгээр, нэмэлт, өөрчлөлт бол зүйл, эсхүл хэсэг, заалт тус бүрээр багцлан тусгана.

[/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

33.5.Энэ хуулийн 33.3.4-т заасан хуулийн төслийн нэр томьёо, ухагдахууны үүслийг тайлбарлахад холбогдох хууль, Монгол Улсын хуулиар соёрхон баталсан, нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан тодорхойлолт, хэм хэмжээг баримталж болно.

[/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

[/Энэ хэсэг т 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

33.6.Хуулийн зохицуулалтыг тайлбарлан хэрэглэхэд хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулга, хуулийн төсөл, Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцэх үеийн хуралдааны тэмдэглэлийг ашиглаж болох бөгөөд эдгээр нь хуулийн албан ёсны тайлбар болохгүй.

[/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

34 дүгээр зүйл.Олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн төсөлд тавих нэмэлт шаардлага

34.1.Олон талт олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн төсөлд тухайн гэрээний хянан баталгаажуулсан монгол хэл дээрх орчуулгыг энэ хуулийн 30 дугаар зүйлд заасан шаардлагыг хангуулж хавсаргана.

[/Энэ хэсэг т 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсэг т 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

34.2.Олон талт олон улсын гэрээний орчуулгыг тухайн гэрээгээр зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан гүйцэтгэж, гадаад хэргийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхлэх асуудлын хүрээнд уг орчуулгыг хянан баталгаажуулна.

34.3.Хоёр талт олон улсын гэрээг талууд тохиролцсоны үндсэн дээр гадаад улсын хэлээр үйлдсэн бол тухайн гэрээг соёрхон батлах тухай хуулийн төсөлд энэ хуулийн 34.1, 34.2-т заасан шаардлага нэгэн адил үйлчилнэ.

34.4.Гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээл, тусламжийн талаарх олон улсын гэрээг орчуулах, орчуулгыг хянан баталгаажуулах үүргийг тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүлээнэ.

34.5.Олон улсын гэрээг соёрхон баталснаар Монгол Улсын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл хууль шинээр батлах шаардлагатай тохиолдолд тухайн хуулийн төслийг хамт боловсруулна.

ТАВДУГААР БҮЛЭГ
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, ӨРГӨН
МЭДҮҮЛЭХ

35 дугаар зүйл. Улсын Их Хурлын тогтоолын төслийн эх бичвэрт тавих шаардлага

35.1. Монгол Улсын Их Хурлын тогтоол /цаашид "Тогтоол" гэх/-ын төсөл дараах шаардлагыг хангасан байна:

35.1.1. Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн, бусад хууль болон Монгол Улсын олон улсын гэрээний заалттай уялдсан байх;

35.1.2. хуулийн заалтыг давтахгүй байх;

35.1.3. хариуцлагын хэм хэмжээ заахгүй байх.

36 дугаар зүйл. Тогтоолын төслийн бүтэц

36.1. Тогтоолын төсөл дараах бүтэцтэй байна:

36.1.1. тогтоолын төслийн гарчиг;

36.1.2. шаардлагатай бол тэмдэглэх хэсэг;

36.1.3. тогтоох хэсэг;

36.1.4. шаардлагатай бол урьд гаргасан шийдвэрийг хүчингүй болсонд тооцох тухай хэсэг;

36.1.5. шаардлагатай бол тогтоол хүчин төгөлдөр болох хугацаа.

36.2. Тогтоолын төслийн гарчиг дараах хэсгээс бүрдэнэ:

36.2.1. "Монгол Улсын Их Хурлын тогтоол" гэсэн толгой;

36.2.2. баталсан он, сар, өдөр /араб тоогоор бичнэ/;

36.2.3. тогтоол баталсан газар /хот/-ын нэр;

36.2.4. тогтоолын нэр. Тогтоолын нэр нь "... тухай" гэж төгсөнө.

36.3. Тогтоолын төслийн тэмдэглэх хэсэгт уг тогтоол гарах болсон үндэслэл, шаардлага, эсхүл хуулийн заалтыг үндэслэсэн байна.

36.4. Тогтоолын төслийн тогтоох хэсэгт уг тогтоолоор шийдвэрлэх асуудлыг энгийн, ойлгомжтой байдлаар томъёолж бичнэ.

36.5. Тогтоолын төслийн бүтцийн үндсэн нэгж нь заалт байх бөгөөд шаардлагатай тохиолдолд түүнийг дэд заалтад хувааж болно.

36.6. Тогтоол хавсралттай байж болох бөгөөд энэ тухай заалтыг "... -ыг хавсралтаар баталсугай.", эсхүл "...-ыг 1, 2, 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай" гэж томъёолно.

36.7. Тогтоолын хавсралтын эхний хуудасны баруун дээд буланд "Монгол Улсын Их Хурлын ... оны ... дугаар тогтоолын хавсралт", эсхүл "Монгол Улсын Их Хурлын ... оны ... дугаар тогтоолын ... дугаар хавсралт" гэж заана.

36.8. Тогтоолын төслийн заалтыг дараах байдлаар дугаарлана:

36.8.1. заалтыг баруун талдаа цэгтэй араб тоогоор /1. гм/;

36.8.2. заалтын доторх дэд заалтыг баруун талдаа хаалт бүхий араб тоогоор /1/ гм/.

37 дугаар зүйл. Тогтоолын төслийг өргөн мэдүүлэх

37.1. Хууль санаачлагч тогтоолын төслөө энэ хуулийн 41.1-д заасан журмын дагуу өргөн мэдүүлнэ.

37.2. Тогтоолын төсөлд энэ хуулийн 40.1-д заасан баримт бичгийг хавсаргасан байна.

37.3. Тогтоолын төсөлд хавсаргах баримт бичиг нь албан хэрэг хөтлөлтийн нийтлэг шаардлагыг хангасан байна.

37.4. Энэ хуулийн 37.1, 37.2 дахь хэсэг нь энэ хуулийн 6.2, 6.3-т хамаарахгүй.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙГ ОЛОН НИЙТЭЭР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ,
САНАЛ АВАХ

38 дугаар зүйл. Хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлэг зохион байгуулах

38.1. Хуульд өөрөөр заагаагүй бол хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс өмнө олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох материалыг баримтжуулан хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрт хавсаргана.

[/Энэ хэсэгт 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

38.2.Хууль санаачлагч албан ёсны цахим хуудсандаа болон хууль тогтоомжийн төсөлд санал авах нэгдсэн цахим системд хууль тогтоомжийн төсөл болон энэ хуулийн 40.1.2, 40.1.3, 40.1.4-т заасан баримт бичгийг байршуулж, хууль тогтоомжийн төсөлд санал өгөх хугацааг тодорхой заана.

[/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

38.3.Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 38.2-т заасан хугацаа 15-аас доошгүй хоног байна. Энэ хугацаанд иргэн, хуулийн этгээд саналаа бичгээр, эсхүл цахим хэлбэрээр өгөх бөгөөд холбогдох этгээд гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

[/Энэ хэсэгт 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

38.4.Хууль санаачлагч худалдаа, хөрөнгө оруулалт, татвар зэрэг бизнесийн орчинд нөлөөлөх хууль тогтоомжийн төсөл боловсруулсан бол энэ хуулийн 40.1.2, 40.1.3, 40.1.4-т заасан баримт бичгийг өөрийн албан ёсны цахим хуудас болон эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд 60 хоногоос доошгүй хугацаанд байршуулж, олон нийтээс санал авна. Хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгыг англи хэл дээр орчуулж, хамтад нь байршуулна.

[/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

[/Энэ хэсэгт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

38.5.Хууль санаачлагч энэ хуулийн 38.3-т заасны дагуу ирүүлсэн саналыг харгалзан үзнэ.

[/Энэ хэсгийн дугаарт 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

38.6.Олон нийтийн хэлэлцүүлгийг дараах хэлбэрээр явуулна:

[/Энэ хэсгийн дугаарт 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

38.6.1.бичгээр санал авах;

[/Энэ заалтын дугаарт 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

38.6.2.уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах;

[/Энэ заалтын дугаарт 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

38.6.3.санал асуулга явуулах;

[/Энэ заалтын дугаарт 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

38.6.4.цахим хэлбэрээр хэлэлцүүлэг явуулах;

[/Энэ заалтын дугаарт 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ заалтад 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

38.6.5.бусад хэлбэр.

[/Энэ заалтын дугаарт 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

38.7.Хууль санаачлагч олон нийтийн хэлэлцүүлгийн хугацаа дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор хуулийн төсөлд тусгасан, эс тусгасан талаарх саналын товъёгийг тайлбар, үндэслэлийн хамт албан ёсны цахим хуудсандаа болон хууль тогтоомжийн төсөлд санал авах нэгдсэн цахим системд байршуулна. Хууль тогтоомжийн төсөлд санал авах нэгдсэн цахим систем энэ хуулийн 45.3-т заасан эрх зүйн мэдээллийн нэгдсэн сангийн нэг бүрэлдэхүүн байна.

[/Энэ хэсгийн дугаарт 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

38.8.Хууль санаачлагчийн боловсруулж байгаа хууль тогтоомжийн төслийн хуулиар нууцад хамааруулсан асуудалтай холбоотой хэсгээр олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахгүй.

[/Энэ хэсэгт 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсгийн дугаарт 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

38.9.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 12.2.5, 12.2.6, 12.2.7, 12.2.8, 12.2.9, 12.2.10, 12.2.11, 12.2.15, 12.2.16, 12.2.18, 12.2.19, 12.2.20, 12.2.21, 12.2.22, 12.4-т заасан хууль тогтоомжийн төсөлд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахгүй байж болно.

[/Энэ хэсгийн дугаарт 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсгийг 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн, энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

38.10.Хууль санаачлагч эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөллөөс энэ хуулийн 38.6.1, 38.6.2-т заасан хэлбэрээр санал авч, хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрт хавсаргана.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

39 дүгээр зүйл.Төрийн байгууллагаас санал авах

39.1.Хууль санаачлагч санаачилж байгаа хууль тогтоомжийн төсөлдөө түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагаас санал авна.

[/Энэ хэсэгт 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

39.2.Төрийн захиргааны төв байгууллага хууль тогтоомжийн төсөлд харьяа болон холбогдох мэргэжлийн байгууллагын саналыг авч нэгтгэн хууль санаачлагчид хүргүүлж болно.

39.3.Хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах зохицуулалт бүхий хуулийн төсөлд Хүний эрхийн Үндэсний Комиссоос, Эрүүгийн хууль, Иргэний хууль, Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль болон шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журамтай холбогдсон хуулийн төсөлд Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокуророос тус тус санал авах бөгөөд ажлын 30 өдрийн дотор санал ирүүлээгүй бол тусгайлан өгөх саналгүй гэж үзнэ.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

39.4.Засгийн газрын санаачилсан хууль тогтоомжийн төсөлд тусгасан асуудал нь Улсын Их Хурлаас байгуулдаг төрийн байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах бол тухайн байгууллагаас санал авна.

[/Энэ хэсгийн дугаарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

39.5.Энэ хуулийн 39.1, 39.3, 39.4-т заасан саналыг бичгээр, эсхүл энэ хуулийн 20.10-т заасан цахим хэлбэрээр үйлдэнэ.

[/Энэ хэсэгт 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

[/Энэ хэсгийн дугаарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

ДОЛООДУГААР БҮЛЭГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСӨЛ ӨРГӨН МЭДҮҮЛЭХ

40 дүгээр зүйл.Хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэр

40.1.Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн төсөлд дараах баримт бичгийг хавсаргана:

40.1.1.хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлэх тухай хууль санаачлагчийн албан бичиг;

40.1.2.хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлал, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан, эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийсэн тайлан;

[/Энэ заалтад 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

[/Энэ заалтад 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ заалтад 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

40.1.3.хууль тогтоомжийн төслийн энэ хуулийн 33 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан товч болон дэлгэрэнгүй танилцуулга;

[/Энэ заалтыг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

40.1.4.дагалдаж өөрчлөлт оруулах хууль тогтоомжийн төсөл;

[/Энэ заалтын дугаарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

40.1.5.хууль тогтоомжийн төсөл батлагдсан тохиолдолд түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо, авах арга хэмжээний санал;

[/Энэ заалтыг 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

40.1.6.олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн төсөлд энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасан журмын дагуу хянан баталгаажуулсан олон улсын гэрээний монгол хэл дээрх орчуулга;

[/Энэ хэсэгт 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ заалтын дугаарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

40.1.7.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүний өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн төслийн тухайд Засгийн газрын санал, дүгнэлт;

[/Энэ заалтын дугаарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

40.1.8.Засгийн газрын өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн төслийн тухайд энэ хуулийн 20.7-20.9-д заасны дагуу санхүү, төсвийн, гадаад хэргийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бичгээр, эсхүл энэ хуулийн 20.10-т заасан цахим хэлбэрээр өгсөн зөвшөөрөл, энэ хуулийн 19¹ дүгээр зүйлд заасны дагуу гаргасан хууль зүйн дүгнэлт;

[/Энэ хэсэгт 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

[/Энэ заалтад 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

[/Энэ заалтын дугаарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

40.1.9.энэ хуулийн 15.2-т заасны дагуу хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлсэн тохиолдолд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвлөмж;

[/Энэ заалтын дугаарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ заалтыг 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

40.1.10.энэ хуулийн 40.1.1-40.1.9-д заасан баримт бичгийн цахим хувь;

[/Энэ заалтын дугаарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ заалтад 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

40.1.11.энэ хуулийн 38.7-д заасан саналын товъёг.

[/Энэ заалтад 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ заалтын дугаарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

40.1.12.энэ хуулийн 13.2.6-д заасан судалгааны тайлан;

[/Энэ заалтыг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

40.1.13.энэ хуулийн 27¹.1-д заасны дагуу батлах захиргааны хэм хэмжээний актын жагсаалт, 27¹.3-т заасан хугацааны талаарх мэдээлэл.

[/Энэ заалтыг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

40.2.Энэ хуулийн 40.1-д заасан баримт бичиг нь албан хэрэг хөтлөлтийн нийтлэг шаардлагыг хангасан байна.

40.3.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115, 117, 118 дугаар зүйлд заасан тайлан, илтгэл энэ хуулийн 40.2-т заасан шаардлагыг хангасан байна.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

[/Энэ хэсгийг 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

40.4.Хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийн цахим хувийг үйлдэх, баталгаажуулах, хүлээлцэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

[/Энэ хэсгийн дугаарт 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

41 дүгээр зүйл.Хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хурал өргөн мэдүүлэх

[/Энэ зүйлийг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

41.1.Хууль санаачлагч энэ хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийг хангаж, хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэхээс өмнө өргөн мэдүүлэх тов тогтоолгох тухай албан бичгийг Улсын Их Хурлын Тамгын газарт хүргүүлнэ.

[/Энэ хэсгийг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

41.2.Улсын Их Хурлын Тамгын газар хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр ирүүлсэн хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийг энэ хуулийн 41.3-т заасны дагуу хянах бөгөөд төслийн бүрдүүлбэрийг хянах

хуудсыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга батална.

[/Энэ хэсгийг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

[/Энэ хэсэг т 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

41.3.Улсын Их Хурлын Тамгын газар хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийг ажлын 5 өдрийн дотор дараах шаардлагыг хангасан эсэхээр хянан үзнэ:

[/Энэ хэсэг т 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

[/Энэ хэсгийг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

41.3.1.энэ хуульд заасан шаардлагыг хангасан эсэх;

[/Энэ заал т-ыг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

41.3.2.хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд боловсруулсан эсэх;

[/Энэ заал т-ыг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

41.3.3.хуулийн төслийг хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан, эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн судалгаанд үндэслэн боловсруулсан эсэх;

[/Энэ заал т-ыг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

41.3.4.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлд заасан хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаарыг хангасан эсэх;

[/Энэ заал т-ыг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

41.3.5.энэ хуулийн 40.1.2-т заасан зардлын тооцооллыг холбогдох журам, зааврын дагуу боловсруулсан эсэх.

[/Энэ заал т-ыг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

41.3.6.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36.15-д заасан хугацааг хангасан эсэх.

[/Энэ заал т-ыг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

41.4.Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга хууль тогтоомжийн төсөл энэ хуульд заасан шаардлагыг хангасан эсэх талаар Улсын Их Хурлын даргад танилцуулах ба шаардлагатай гэж үзвэл Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13.1.14-т заасан өргөн мэдүүлэх хууль, тогтоолын төслийн талаар хууль зүйн дүгнэлт гаргуулж болно.

[/Энэ хэсэг т 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар нэмэл т, өөрчлөл т оруулсан./](#)

[/Энэ хэсгийг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

[/Энэ зүйлийг 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

41.5.Энэ хуулийн 41.4-т заасан хууль зүйн дүгнэлтийг Улсын Их Хурлын Тамгын газар ажлын 5 өдрийн дотор гаргаж, Улсын Их Хурлын даргад танилцуулна.

[/Энэ хэсгийг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

[/Энэ хэсгийг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

41.6.Төслийг өргөн мэдүүлэх талаар Улсын Их Хурлын даргаас товлосон хугацааг Улсын Их Хурлын Тамгын газар хууль санаачлагчид албан бичгээр мэдэгдэх бөгөөд хууль санаачлагч уг хугацаанд хууль тогтоомжийн төслөө Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлнэ.

[/Энэ хэсгийг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

41.7.Улсын Их Хурлын Тамгын газар энэ хуулийн 41.3-т заасны дагуу хянаж, эсхүл 41.5-д заасны дагуу хууль зүйн дүгнэлт гаргасан хууль тогтоомжийн төсөл хуульд заасан шаардлагыг хангаагүй гэж үзсэн бол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Улсын Их Хурлын даргад танилцуулж, хууль тогтоомжийн төслийг энэ хуульд заасан шаардлага хангуулахаар хууль санаачлагчид буцаана.

[/Энэ хэсгийг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

41.8.Улсын Их Хурлын Тамгын газраас хуулийн төслийн бүрдүүлбэрийг хянасан талаарх албан бичгийг хууль санаачлагчид ажлын 14 өдрийн дотор мэдэгдээгүй бол бүрдүүлбэр хангасанд тооцно.

[/Энэ хэсгийг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

41.9.Хууль санаачлагч энэ хуулийн 23.1, 25.1-д заасан хуулийн төсөл, Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хамт тусад нь өргөн мэдүүлнэ.

[/Энэ хэсгийг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

41.10.Хуулийг дагаж мөрдөж эхэлсэн өдрөөс хойш тухайн хууль болон түүний зүйл, хэсэг, заалт, дэд заалтын дагаж мөрдөх хугацаанд өөрчлөлт оруулах хуулийн төсөл өргөн мэдүүлэхгүй.

[/Энэ хэсгийг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

НАЙМДУГААР БҮЛЭГ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН САН БҮРДҮҮЛЭХ, СИСТЕМЧЛЭХ, ХУУЛЬ
ТОГТООМЖИЙГ НИЙТЛЭХ, ОЛОН НИЙТЭД СУРТАЛЧЛАХ

[/Энэ бүлгийн гарчигт 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

[/Энэ бүлгийн гарчгийг 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчилсөн/](#)

42 дугаар зүйл.Хууль тогтоомжийн албан ёсны эх

42.1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу ёсчилсон Улсын Их Хурлын Тамгын газарт хадгалах хууль тогтоомжийн хувийг албан ёсны эх гэнэ.

42.2.Хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэр, хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хурлын Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх үе шатанд бүрдүүлсэн баримт бичгийг байнга хадгална.

42.3.Хууль тогтоомжийн архивын нэгж бүрдүүлэх журмыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга батална.

[/Энэ хэсэгт 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

43 дугаар зүйл.Хууль тогтоомжийг нийтлэх

[/Энэ зүйлийн гарчигт 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

43.1.Хууль тогтоомжийг Улсын Их Хурлын Тамгын газар "Төрийн мэдээлэл" эмхэтгэлд нийтэлнэ.

[/Энэ хэсэгт 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

43.2.Монгол Улсын олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийг соёрхон баталсан гэрээ, түүний хянан баталгаажуулсан монгол хэл дээрх орчуулга, эх бичвэрийн хамт "Төрийн мэдээлэл" эмхэтгэлд нийтэлнэ.

[/Энэ хэсэгт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/](#)

43.3."Хууль тогтоомжийн эмхэтгэл" д нийтэлсэн хууль тогтоомж албан ёсны өхтөйгөө зөрчилдөөн тохиолдолд албан ёсны өхийг баримтална.

[/Энэ хэсгийг 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

44 дүгээр зүйл.Хууль тогтоомжийг хүргэх

44.1.Улсын Их Хурлын Тамгын газар хууль тогтоомжийн албан ёсны эхээс хуулбарласан хувийг холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулна.

44.2.Хууль тогтоомжийн албан ёсны эхээс хуулбарлан хүргүүлсэн хувийг хүлээж авсан төрийн байгууллага хууль тогтоомжийн санг бүрдүүлнэ.

44.3.Холбогдох төрийн байгууллага нь хүний хувийн мэдээлэл, төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад хууль тогтоомжийн хувийн хэрэгтэй иргэд, олон нийт чөлөөтэй танилцах нөхцөлийг бүрдүүлнэ.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

44.4.Энэ хуулийн 44.2-т заасан хууль тогтоомжийн сан бүрдүүлэх, системчлэн ангилж, хууль тогтоомжийн хувийн хэрэг хөтлөх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

[/Энэ хэсгийн дугаарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан /](#)

45 дугаар зүйл.Хууль тогтоомжийн сан бүрдүүлэх

45.1.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэдээлэл, лавлагаа өгөх зорилгоор Монгол Улсын хүчин төгөлдөр хууль тогтоомжийн нэгдсэн санг цаасан болон цахим хэлбэрээр бүрдүүлэх, хууль тогтоомжийг системчлэх ажлыг хариуцан зохион байгуулна.

45.2.Энэ хуулийн 45.1-д заасан санд Монгол Улсын олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийг соёрхон баталсан тухайн гэрээний хамт оруулна.

45.3.Энэ хуулийн 45.1-д заасан хууль тогтоомжийн цахим санг Хууль зүйн үндэсний хүрээлэн эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд хариуцан байршуулах бөгөөд хууль тогтоомжийн "Төрийн мэдээлэл" эмхэтгэлд нийтлэгдсэн эх хувь, түүний үзэл баримтлал, хууль тогтоомжид оруулсан нэмэлт, өөрчлөлтийн түүх, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг хавсаргана. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, ашиглах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

[/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

45.4.Энэ хуулийн 45.3-т заасан эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан нь хууль тогтоомж, бусад эрх зүйн акт болон хууль тогтоомжийн төслийг Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх, уялдааг шалгах боломжтой мэдээллийн шинэ технологид тулгуурласан шийдэл бүхий байна.

[/Энэ хэсгийн 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

45.5.Хууль тогтоомжийн цахим сан нь хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд тохирсон хэлбэрээр ашиглах боломжтой байна.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

46 дугаар зүйл.Хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах

[/Энэ зүйлийн гарчиг т 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан/](#)

46.1.Хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо Улсын Их Хурлын Тамгын газартай хамтран зохион байгуулж болно.

[/Энэ хэсэг т 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан/](#)

46.2.Ерөнхийлөгчөөс санаачилсан хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлыг Ерөнхийлөгчийн Тамгын газар зохион байгуулж болно.

[/Энэ хэсэг т 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан/](#)

46.3.Засгийн газар, холбогдох төрийн захиргааны төв байгууллага, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий бусад байгууллага хууль тогтоомжийг өөрийн бүрэн эрх, чиг үүргийн дагуу харьяалах салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна.

[/Энэ хэсэг т 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмэл т оруулсан./](#)

[/Энэ хэсэг т 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан/](#)

46¹ дүгээр зүйл.Хууль тогтоомжийн орчуулга хийх

[/Энэ зүйлийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

46¹.1.Засгийн газар шаардлагатай тохиолдолд хууль тогтоомжийн орчуулгыг англи хэлээр хийнэ.

[/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

46¹.2.Хууль тогтоомжийн орчуулгын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх бөгөөд хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээс санхүүжүүлж болно.

[/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

46¹.3.Хууль тогтоомжийн орчуулгын санг бүрдүүлэх, эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд байршуулах ажлыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

[/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

46¹.4.Энэ хуулийн 38.4-т заасан хууль тогтоомжийн орчуулгыг тухайн хууль тогтоомж батлагдсанаас хойш 90 хоногийн дотор эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд байршуулна.

[/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ

47 дугаар зүйл.Хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах нийтлэг арга хэмжээ

47.1.Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжийг хүлээн авсан даруйд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хяналтын хувийн хэрэг нээж, харьяалах хүрээний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.

48 дугаар зүйл.Хуулиар тусгайлан эрх олгосны дагуу нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон акт гаргах

48.1.Хуульд тусгайлан зааж эрх олгоосноос бусад тохиолдолд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн акт гаргахыг хөриглөнө.

48.2.Хуульд нийцээгүй, эсхүл хуулиар олгоосон эрхийг хэтрүүлэн гаргасан нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг дагаж мөрдөхгүй.

48.3.Хуульд өөрөөр заагаагүй бөл нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн акт гаргах эрх хуулиар олгоосон этгээд уг эрхээ бусдад шилжүүлэхийг хөриглөнө.

АРАВДУГААР БҮЛЭГ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ

/Энэ бүлгийн гарчигт 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

49 дүгээр зүйл.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх байгууллага

/Энэ зүйлийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

49.1.Дараах хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газар болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг холбогдох байгууллага хэрэгжүүлнэ:

49.1.1.Улсын Их Хурлын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг зохицуулж байгаа хууль тогтоомж;

49.1.2.Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын бүтэц, бүрэлдэхүүн, үйл ажиллагааны журмыг зохицуулж байгаа хууль тогтоомж.

/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

49.2.Энэ хуулийн 49.1, 49.3-т зааснаас бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг холбогдох төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

49.3.Энэ хуулийн 15.7.1-д заасан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг Хууль зүйн үндэсний хүрээлэн /цаашид “Хүрээлэн” гэх/ хэрэгжүүлнэ.

/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

49.4.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хөндлөнгийн байгууллагаар үнэлгээ хийлгэх буюу хамтран ажиллаж болно.

/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

49.5.Хүрээлэнгийн үйл ажиллагааны дүрмийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

49.6.Хүрээлэн энэ хуулийн 15.7.1-д зааснаас бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээ болон энэ хуулийн 12.1.2, 12.1.3, 12.1.4-т заасан судалгааг захиалгаар гэрээний үндсэн дээр хийж болно.

/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

49.7.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг тухайн төрийн захиргааны төв байгууллага хариуцан зохион байгуулна.

/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

49.8.Энэ хуулийн 49.2, 49.3-т заасан үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13.7-д заасны дагуу Улсын Их Хурлын хяналт шалгалтын мэдээллийн нэгдсэн санд тухай бүр байршуулна.

/Энэ хэсгийг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн./

50 дугаар зүйл.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ

/Энэ зүйлийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./

50.1.Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээг дараах чиглэлээр хийнэ:

/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./

50.1.1.хууль тогтоомжийн зорилгыг хангаж байгаа түвшинг тодорхойлох;

/Энэ заалтыг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./

50.1.2.хууль тогтоомжийн үзэл баримтлалд тодорхойлсон үр дүнд хүрэх байдлыг тогтоох;

/Энэ заалтыг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./

50.2.Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийх хяналт шинжилгээг энэ хуулийн 12.1.5-д заасан аргачлалын дагуу хийнэ.

/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./

51 дүгээр зүйл.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ

51.1.Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах, багц хуулийн төсөл боловсруулахад түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг

нөлөөллийг илрүүлж, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлно.

[/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

51.2.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг энэ хуулийн 12.1.6-д заасан аргачлалын дагуу хийнэ.

51.3.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно.

[/Энэ хэсгийг 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

51.4.Хууль тогтоомжийн зохицуулах харилцааны онцлог, асуудлаас хамааран хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийхдээ хууль тогтоомжид бүхэлд нь, эсхүл түүний зарим зүйл, хэсэг, заалтыг сонгож болно.

[/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

51.5.Энэ хуулийн 49.1, 49.2-т заасан этгээд хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг энэ хуулийн 45.3-т заасан эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд тухай бүр байршуулна.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

52 дугаар зүйл.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний дүнг хэлэлцэх

[/Энэ зүйлийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

52.1.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний дүнг Улсын Их Хурал, Засгийн газар жилд нэг удаа тогтмол хэлэлцэж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, хууль тогтоомжийг хооронд нь уялдуулах, системчлэн кодификаци хийх, шинээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

[/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

52.2.Улсын Их Хурал хууль тогтоомжийн төслийг хэлэлцэн батлахдаа тухайн хууль тогтоомжийн ач холбогдол, зохицуулалтын онцлогийг харгалзан шаардлагатай бол уг хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, дүнг танилцуулах хугацаатай үүргийг Засгийн газарт өгч болно.

[/Энэ хэсгийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

53 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

53.1.Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

[/Энэ хэсэг т 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД